

20.. оны ... дугаар сарын  
...-ны өдөр

Улаанбаатар хот

## **ЭРДЭНЭСИЙН САНГИЙН ТУХАЙ** **/Шинэчилсэн найруулга/**

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ** **НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

#### **1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын эрдэнэсийн эх нөөцийг хамгаалах, төрийн эрдэнэсийн сан /цаашид "эрдэнэсийн сан" гэх/-г эрхлэх, бүрдүүлэх, хамгаалах, арвижуулах, уул сангаас хөрөнгө гүйлгээнд оруулах, захиран зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### **2 дугаар зүйл.Эрдэнэсийн сангийн тухай хууль тогтоомж**

2.1.Эрдэнэсийн сангийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Төв банк (Монголбанк)-ны тухай хууль,Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Валютын зохицуулалт, гадаад валютын улсын нөөцийг эзэмшиж, удирдахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

#### **3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

3.1.Энэ хуульд хэрэглэсэн нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."эрдэнэс" гэж түүхий эд, хайлш, химийн нэгдэл, бүтээгдэхүүн зэрэг ямар ч байдалд байгаа үнэт металл, эрдэнийн чулуу, түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйл, байгалийн төрцийг;

3.1.2."үнэт металл" гэж алт, мөнгө, платина болон түүний бүлэгт багтдаг палладий, иридий, родий, рутений, осмийг;

3.1.3."үнэт чулуу" гэж доржпалам, бадмаараг, маргад эрдэнэ, индранилыг;

3.1.4."эрдэнэсийн сан" гэж төрийн нэрийн өмнөөс Монголбанк эрхлэн хуримтлуулж, хадгалж, хамгаалж, хэрэглэх зэргээр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулж байгаа эрдэнэс, түүний дагалдах зүйл, хөрөнгийн хуримтлалыг;

3.1.5."байгалийн төрц" гэж онцгой чаминдүрс хэлбэртэй, ховор өнгөтэй,, байгалийн тогтоцоороо олдсон үнэт металл, эрдэнийн чулууг;;

3.1.6."эрдэнийн чулуу" гэж олон улсад хэвшсэн ангилалыг харгалзан, хуульд тогтоомжид тодорхойлсон ангилалд хамрагдах үнэт, хагас үнэт чулуу, гоёл чимэглэлийн чулууг.

#### **4 дүгээр зүйл.Эрдэнэсийн сан, түүний ангилал**

4.1.Эрдэнэсийн сан нь төрийн өмчлөлд байна.

4.2.Эрдэнэсийн санг үндсэн болон гүйлгээ санд хуваана.

4.3.Үндсэн сан нь дараах эрдэнэс бүхий байнгын болон байнгын бус хэсгээс бүрдэнэ.

4.3.1.байнгын хэсэгт худалдах, шилжүүлэх, захиран зарцуулахыг хориглосон Монгол Улсын хуваагдашгүй өмч болох эрдэнэс орно;

4.3.2.байнгын бус хэсэгт Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу эрдэнэсийн санд шилжүүлсэн олон улсын жишигт хүргэж цэвэршүүлсэн үнэт металл, засаж өнгөлсөн эрдэнийн чулуу, түүх, соёлын үнэт дурсгалт зүйл, үнэт металлаар хийж нөөцөд авсан зоос орно.

4.4.Гүйлгээ санд үйлдвэрлэл, судалгаа, дурсгалын чиглэлээр гүйлгээнд оруулах энэ зүйлийн 4.3 дахь хэсэгт зааснаас бусад Эрдэнэсийн санд хадгалагдаж байгаа бүх эрдэнэс хамаарна.

4.5.Эрдэнэсийн сангийн байнгын хэсэгт зөвхөн түүх, соёлын хосгүй үнэтдурсгалт зүйлийг оруулна.

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ ЭРДЭНЭСИЙН САНГИЙН ТАЛААР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭДЛЭХ БҮРЭН ЭРХ**

#### **5 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх**

5.1.Улсын Их Хурал эрдэнэсийн сангийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1.үндсэн сангийн байнгын болон байнгын бус хэсэгт байвал зохих эрдэнэсийн нэр төрөл, хэмжээг тогтоох;

5.1.2.эрдэнэсийн сангийн жилийн орлого, зарлагын хэмжээ болон гүйцэтгэлийн тайланг батлах;

5.1.3.эрдэнэсийн үндсэн сангаас үнэт металл, үнэт чулуу гадаадад худалдах, гадаадаас худалдан авах шийдвэр гаргах;

5.1.4.олборлосон үнэт металл, үнэт чулууг улсын эрдэнэсийн санд зориулан худалдан авах доод хэмжээг тогтоох;

5.1.5.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

## **6 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх**

6.1.Засгийн газар Эрдэнэсийн сангийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.Улсын Их Хурлаас тогтоосон хэмжээнд гүйлгээний сангаас үнэт металл, үнэт чулуу худалдах асуудлыг Монголбанктай хамтран шийдвэрлэх;

6.1.2.Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн жилийн орлого, зарлагын хэмжээ болон гүйцэтгэлийн тайлантай танилцах;

6.1.3.Эрдэнэсийн сангийн үндсэн санд нэмж оруулах түүх, соёлын хосгүй үнэт зүйлийн талаар Монголбанкинд санал гаргах;

6.1.4.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

## **7 дугаар зүйл.Монголбанкны бүрэн эрх**

7.1.Монголбанк эрдэнэсийн сангийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.эрдэнэсийн санг эрхлэх, түүний үйл ажиллагааны журам батлах, холбогдох шийдвэр гаргах;

7.1.2.эрдэнэсийн сангийн эрдэнэс, хөрөнгө, эд зүйлийн хөдөлгөөний бүртгэл хийж, төлбөр тооцоог гүйцэтгэх;

7.1.3.хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу үндсэн болон гүйлгээ сангийн орлогыг нэмэгдүүлэх, зарлагын гүйцэтгэлийг хангах;

7.1.4.эрдэнэсийн үндсэн сангийн байнгын бус хэсгээс үнэт металл, үнэт чулуу гадаадад худалдаж гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж гаргасан шийдвэрийг нь хэрэгжүүлэх;

7.1.5.хуульд заасан үйл ажиллагааны дагуу худалдан авах үнэт металл, эрдэнийн чулууны сорьц тогтоох;

7.1.6.эрдэнэсийн санд эрдэнэс худалдан авах, гүйлгээ сангаас зөвшөөрөгдсөн хэмжээгээр эрдэнэс худалдах, арилжих, үнийг тогтоох;

7.1.7.Үнэт металл, эрдэнийн чулуу, зоос зэргийн олон улсын зах зээлийн үнийн судалгааг гаргах;

7.1.8.Монгол Улсын болон олон улсын нийтлэг ач холбогдол бүхий тэмдэглэлт ой зэрэг онцгой чухал үйл явдлыг тохиолдуулан хууль тогтоомжийн дагуу үнэт металлаар дурсгалын зоос үйлдвэрлүүлэх, энэ хуулийн 7.1.1-д заасан журмын дагуу үзэсгэлэн гаргах;

7.1.9.эрдэнэсийн санг нэмэгдүүлэх хэмжээ, гүйлгээ хөрөнгийн орлого, зарлагын жилийн төлөвлөгөө, тэнцлийг болон жил бүрийн худалдан авах эрдэнэсийн доод хэмжээг тодорхойлж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж гаргасан шийдвэрийг нь хэрэгжүүлэх;

7.1.10.эрдэнэсийн санг эрхлэх нэгжийг эрдэнэсийн сангийн зүйлийг хэмжих, жинлэх, сорьц шалгах, өнгөлөх, хадгалж хамгаалах, тээвэрлэх, шаардлагатай холбоо, дохиоллын болон бусад багаж, тоног төхөөрөмж, сэлбэг, химийн бодис зэргээр хангах;

7.1.11.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ЭРДЭНЭСИЙН САНГ ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

### **8 дугаар зүйл.Эрдэнэсийн сангийн үйл ажиллагаа**

8.1.Эрдэнэсийн сангийн эрдэнэсийг нэмэгдүүлэх, хамгаалах, хадгалах, хадгалуулах, худалдан авах, худалдах, зарцуулах, цэвэршүүлэх, байршуулах, үнэлгээ хийлгэх, сэлбэн тордох, сэргээн засварлуулах, үзэсгэлэн зохион байгуулах, эрдэнэсийн сангийн талаар мэдээлэх, хэвлэн нийтлэх, эдгээртэй холбоотой бусад ажил, үйлчилгээ нь эрдэнэсийн санг эрхлэх үйл ажиллагаанд хамаарна.

### **9 дүгээр зүйл.Зохион байгуулалт**

9.1.Монголбанкны бүтцэд энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан ажлыг эрхлэх нэгж байх бөгөөд үйл ажиллагааг нь Монголбанкны Ерөнхийлөгч байнгын удирдлагаар хангана.

9.2.Монголбанкны Ерөнхийлөгч эрдэнэсийн санг эрхлэх нэгжийн бүтцийг тогтооно.

9.3.Монголбанкны Ерөнхийлөгч эрдэнэсийн санг эрхлэх нэгжийн орон тоо, цалингийн санг Монголбанкны зардлын төсөвт багтаан тогтооно.

## **10 дугаар зүйл.Эрдэнэсийн сангийн орлого**

10.1.Эрдэнэсийн сангийн орлого нь гадаад, дотоодын банк, хүн, хуулийн этгээд, бусад этгээдээс төрд худалдсан, бэлэглэсэн, хандивласан, түүнчлэн хууль тогтоомжийн дагуу хураасан, дайчлан авсан болон хадгалуулсан, тушаасан эрдэнэсээс бүрдэнэ.

## **11 дүгээр зүйл.Эрдэнэсийн сангийн гүйлгээ сангийн зарлага**

11.1.Эрдэнэсийн сангийн гүйлгээ сангаас дараахь журмаар зарлага гаргана:

11.1.1.Үнэт металл, эрдэнийн чулуу, зоосыг олон улсын зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас тогтоосон үнээр худалдах;

11.1.2.Үнэт металл, эрдэнийн чулууг засах, цэвэршүүлэх, сэлбэн тордох явцад гарсан хорогдлыг хасах.

## **12 дугаар зүйл.Эрдэнэсийн сангийн бүртгэл**

12.1.Эрдэнэсийн санд байгаа эрдэнэс, бусад хөрөнгийн хувийн хэргийг хөтөлж, эрдэнэсийн сангийн бүртгэл-мэдээллийн санд бүртгэнэ.

12.2.Энэ хуулийн 12.1-т заасан бүртгэл нь төрийн нууцад хамаарах бөгөөд Засгийн газар, Монголбанкинд тус бүр нэг хувь хадгалагдана.

12.3.Монголбанк Эрдэнэсийн сангийн хөрөнгө, эд зүйлсийг цахим хэлбэрээр бүртгэж, гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулж болно.

12.4.Монголбанк Эрдэнэсийн сангийн хөрөнгө, эд зүйлсийг холбогдох хуулийн дагуу өөрийн санхүүгийн тайлан тэнцэлд тусгаж бүртгэнэ.

12.5.Алт, платина, түүний бүлэгт багтдаг металлыг миллиграммын, мөнгийг граммын нарийвчлалтайгаар үнэт чулууг каратаар тус тус жинлэн бүртгэж, тооцоолно.

12.6.Эрдэнэсийн сангийн үнэт металл, эрдэнийн чулуу, тэдгээрээр хийсэн эдлэл, түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг нэг эд хариуцагчаас нөгөөд шилжүүлэхдээ нэг бүрчлэн тоолж, жинлэж, бүртгэлтэй тулган тооцож, удирдлагын хяналттайгаар хүлээлцэнэ.

12.7.Эрдэнэсийн сангийн бүртгэл, хадгалалт, хяналтын журмыг Монголбанкны Ерөнхийлөгч батална.

### **13 дугаар зүйл.Эрдэнэсийн хадгалалт**

13.1.Эрдэнэсийн санд байгаа бүх эрдэнэсийн чанар байдлыг нь алдагдуулахгүйгээр тусгайлан төхөөрөмжлөгдсөн зориулалтын байр, саванд хадгална.

13.2.Эрдэнэсийн сангийн эрдэнэсийг сэлбэн тордох, сэргээн засварлах, сайжруулах, бүрэн бүтэн байлгахтай холбоотой үйлчилгээг энэ хуулийн 7.1.1-д заасан журамд заасны дагуу гүйцэтгэнэ.

13.3.Түүх, соёлын хосгүй үнэт, үнэт зүйлийг түүнийг өмчлөгч аливаа этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр Монголбанк хадгалах, түүнтэй холбоотой ажил үйлчилгээг үзүүлж болно.

13.4.Энэ хуулийн 13.3-т заасан хадгалах зүйлийн шаардлагыг Монголбанкны Ерөнхийлөгч болон Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

### **14 дугаар зүйл.Эрдэнэсийн сангийн харуул хамгаалалт**

14.1.Эрдэнэсийн сан төрийн тусгай хамгаалалтад байна.

14.2.Эрдэнэсийн сангийн хамгаалалтыг Монголбанкттай байгуулсан гэрээний дагуу төрийн тусгай хамгаалалтын газар эрхлэн гүйцэтгэнэ.

14.3.Үнэт металл, эрдэнийн чулуу, тэдгээрээр хийсэн эдлэл, түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг эрдэнэсийн санд хүлээн авах, шилжүүлэх, байршуулах, эрдэнэсийн сангаас гаргах, тээвэрлэх ажлыг тусгай хамгаалалттайгаар гүйцэтгэнэ.

14.4.Эрдэнэсийн сангийн харуул, хамгаалалтын журмыг Монголбанкны Ерөнхийлөгч, төрийн тусгай хамгаалалтын газрын дарга хамтран батална.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭД, БУСАД БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ҮҮРЭГ**

### **15 дугаар зүйл. Хүн, хуулийн этгээд, бусад байгууллагын эрх, үүрэг**

15.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт эрдэнэс эзэмшигч хүн, хуулийн этгээд, бусад байгууллага нь эрдэнэсийн санд худалдах эрдэнэс тэдгээрээр хийсэн эдлэлийг сорьц тогтоох эрх бүхий хуулийн этгээд, эсхүл сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар сорьц тогтоолгон баталгаажуулсан байх үүрэгтэй.

15.2.Хүн, хуулийн этгээд, бусад байгууллага нь эрдэнэсийн санд худалдах болон хадгалуулах эрдэнэсийн үнийг хэлэлцэн тохирох, нэхэмжлэн авах эрхтэй.

15.3.Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь Монголбанкны хүсэлтийн дагуу түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийн бүртгэл, мэдээллийг гаргаж өгнө.

## **ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **16 дугаар зүйл.Хяналт шалгалт**

16.1.Эрдэнэсийн сангийн байдал, түүнийг эрхлэх үйл ажиллагаанд Монголбанкны дотоод хяналт шалгалт хийх чиг үүрэг бүхий газар, эрх бүхий этгээд шалгалт хийнэ.

16.2.Монголбанк жил бүр эрдэнэсийн сангийн үлдэгдэлд тооллого явуулан дүгнэж, тайланг Улсын Их Хуралд танилцуулна.

### **17 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

17.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

17.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

### **18 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

18.1.Энэ хуулийг 20... оны ... дүгээр сарын ...ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ